

2015 оны 01-р сарын мэдээ

Сайхан сум

2015.02.03

Сумын хэмжээнд бүх төр, төсвийн байгууллагууд 1 дүгээр сарыг “Төлөвлөгөөний сар” болгон зарласан. Энэ хүрээнд бүх төрийн албан хаагчид өөрсдийн ажлын төлөвлөгөө болон дарга эрхлэгч нар байгууллагын төлөвлөгөөгөө гарган батлуулж ажиллаа.

ЗДТГ-ын даргын тушаалаар байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлага, байгууллагын соёл, үнэт зүйлсийг бий болгох, чанарын удирдлагын тогтолцоо ISO-9001 нэвтрүүлэх, байгууллагын дотоод систем able программыг нэвтрүүлэх зорилгоор албан хаагчдыг 7 баг болгон ажиллаж байна.

Мөн байгууллагын албан хаагчдын харилцааны соёл, хувцаслалтанд тавих шаардлага, журмыг батлан хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр Засаг даргын Зөвлөлийн хурал болон бусад шуурхай хурлыг тухай бүр нь зарлан хуралдуулж мэдээлэл хийж байна.

Сумын Засаг дарга бүх байгууллагын дарга эрхлэгч нартай үр дүнгийн гэрээ байгууллаа.



ЗДТГ-ын дарга бүр төрийн захиргааны албан хаагчидтай үр дүнгийн гэрээ, үйлчилгээний албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгууллаа.



3. Сумын Соёлын төвөөс хөдөлгөөний идэвхитэй байдал, залуусын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх чиглэлээр Пүрэв гариг бүр байгууллагууд ээлжлэн “Бүжиглэх өдөр” арга хэмжээг зохион байгуулж байна.

Сайхан сум нь Мануулт, Угалз, Хульж, Их хүрэмт, Сайхан-Овоо гэсэн 6 багийн нийт 1065 өрхөд 3652 хүн амьдардаг. Мануулт багийн Засаг дарга Н.Нямсайхан, Угалз багийн Засаг дарга Ц.Мягмардорж, Хульж багийн Засаг дарга Л.Пүрэвсүрэн, Ундрах багийн Засаг дарга М.Ганбат, Их хүрэмт багийн Засаг дарга Э.Банзрагч, Сайхан-Овоо багийн Засаг дарга Л.Сүхбаатар нар тус тус багийн иргэддээ үйлчилж байна.

